

**ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР
ЗАСГИЙН ГАЗАРТ ҮҮРЭГ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

/Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2017.07.05

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байдаг.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийн заалтыг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн 2016 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ҮҮРЭГ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1.Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 68 хуулийн 262 заалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын 111 хуулийн 376 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нь хяналтанд авсан нийт хуулийн 44 буюу 64.7 хувь, 204 заалт буюу 77.9 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна. Үлдсэн 67 хуулийн 172 заалтын хэрэгжилтийн мэдээний хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас өмнөх онуудад бүрэн хэрэгжиж, хяналтнаас хассан хуулийн хэрэгжилтийн мэдээнүүд болно.

Мэдээнээс үзэхэд давхардсан тоогоор 77 хуулийн 170 заалт буюу 45.3 хувь нь хэрэгжсэн, 56 хуулийн 148 заалт буюу 39.4 хувь нь хэрэгжих шатанд байгаа, 5 хуулийн 9 заалт буюу 1.5 хувь нь хэрэгжээгүй, 11 хуулийн 29 заалт буюу 7.8 хувь нь хугацаа болоогүй, 13 хуулийн 17 заалт буюу 4.5 хувь нь үнэлгээгүй, 2 хуулийн 2 заалт буюу 0.5 хувь нь хүчингүй болсон байна.

2.2.Монгол Улсын хуулиар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн

заалтын хэрэгжилт

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын нийт 16 хуулийн 44 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 22 хуулийн 64 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлснээс /давхардсан тоогоор/ 15 хуулийн 24 заалт буюу 37.5 хувь нь хэрэгжсэн, 13 хуулийн 30 заалт буюу 46.8 хувь нь хэрэгжих шатанд, 2 хуулийн 5 заалт буюу 7.8 хувь нь хэрэгжих хугацаа болоогүй, 2 хуулийн 3 заалт буюу 4.6 хувь нь үнэлгээгүй гэж ирүүлсэн байна.

Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	Хууль /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	16	44	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	22	64	
Үүнээс:			
- Хэрэгжсэн	15	24	37.5
- Хэрэгжих шатанд	13	30	46.8
- Хугацаа болоогүй	2	5	7.8
- Үнэлгээгүй	2	3	4.6

2.3. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

- 2011 оны 10 дугаар сард батлагдсан “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 15 дугаар зүйлийн 15.5, 17 дугаар зүйлийн 17.4, 20 дугаар зүйлийн 20.6, 21 дүгээр зүйлийн 21.3, 21.5, 23 дугаар зүйлийн 23.3, 25 дугаар зүйлийн 25.3, 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалт;
- 2011 оны 02 дугаар сард батлагдсан “Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалт;
- 2015 оны 12 дугаар сард батлагдсан “Эрчим хүч хэмнэлтийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтуудын хэрэгжилтийн мэдээг тус тус ирүүлээгүй байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

2016 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газарт үүрэг өгсөн Улсын Их Хурлын нийт 83 тогтоолын 303 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд, бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 74 тогтоолын 194 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд 9 тогтоолын 109 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 74 тогтоолын 194 заалтын 98 заалт буюу 50.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 73 заалт буюу 37.6 хувь нь хэрэгжих шатанд, 11 заалт

буюу 5.7 хувийн хэрэгжих хугацаа болоогүй, 2 заалт буюу 1.0 хувь хэрэгжээгүй, 10 заалт буюу 5.2 хувь нь үнэлгээгүй ирүүлсэн байна.

3.2. Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын нийт 26 тогтоолын 47 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар 29 тогтоолын 70 заалтын мэдээг ирүүлсэн байна. Эдгээр тогтоолуудын /давхардсан тоогоор/ 15 тогтоолын 36 заалт буюу 51.4 хувь нь хэрэгжсэн, 13 тогтоолын 25 заалт буюу 35.7 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 5 заалт буюу 7.1 хувь нь үнэлгээгүй, 4 тогтоолын 4 заалт буюу 5.7 хувь нь хугацаа болоогүй гэж ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	26	47	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	29	70	
<i>Үүнээс:</i>			
- Хэрэгжсэн	15	36	51.4
- Хэрэгжих шатанд	13	25	35.7
- Үнэлгээгүй	3	5	7.1
- Хугацаа болоогүй	4	4	5.7

3.3. Гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн мэдээг ирүүлэхдээ тогтоолуудын нэр, заалтуудыг давхардуулан ирүүлсэн байна. Тухайлбал: Улсын Их Хурлын 2010 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2 тогтоол болгон ирүүлсэн байна.

Мөн “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого батлах тухай” 2015 оны 63 дугаар тогтоолыг давхардуулан ирүүлсэн байна.

ДӨРӨВ.УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2016 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 93 тогтоолын 505 заалтыг хяналтанд авснаас Засгийн газрын Хэрэг эрхлэх газар 2016 оны жилийн эцсийн байдлаар 55 тогтоолын 272 заалтын буюу хяналтанд авсан нийт заалтын 53.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 55 тогтоолын 272 заалтаас 42 тогтоолын 121 заалт буюу 44.4 хувь нь хэрэгжсэн, 37 тогтоолын 92 заалт буюу 33.8 хувь нь хэрэгжих шатанд, 7 тогтоолын 8 заалт буюу 2.9 хувь нь хэрэгжээгүй, 7 тогтоолын 40

заалт буюу 14.7 хувь нь хэрэгжих хугацаа болгоогүй бол 8 тогтоолын 11 заалт буюу 4.04 хувь нь үнэлээгүй ирүүлсэн байна.

4.2. Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Эдийн засгийн байнгын хорооны Засгийн газарт үүрэг өгсөн нийт 12 тогтоолын 74 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2016 оны жилийн эцсийн байдлаар Эдийн засгийн байнгын хорооны 6 тогтоолын 32 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн нийт тогтоолын 43.2 хувь болж байна.

Эдгээр тогтоолуудын /давхардсан тоогоор/ 4 тогтоолын 21 заалт буюу 65.6 хувь хэрэгжсэн, 3 тогтоолын 7 заалт буюу 21.8 хувь хэрэгжих шатанд, 2 тогтоолын 4 заалт буюу 12.5 хувь нь үнэлгээгүй гэж ирсэн байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	БХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	12	74	100.0
Үүнээс:			
- Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	6	32	43.2
Үүнээс:			
- Хэрэгжсэн	5	21	65.6
- Хэрэгжих шатанд	3	7	21.8
- Үнэлгээгүй	2	4	12.5

4.3. Гарсан зөрчил

Хяналтанд байгаа нийт тогтоолын талаас илүү хувийх нь хэрэгжилтийн мэдээг Засгийн газраас ирүүлээгүй байна. Тухайлбал,

- 2012 онд батлагдсан “Валютын ханш, газрын тосны бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах талаар цаашид авах арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын 14 заалт;
-
- 2015 онд батлагдсан “Түлш, эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 02 дугаар тогтоолын 1.5 дахь заалт.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар бүрэн биелэсэн дараах зүйл, заалтыг хяналтаас хасах саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн байна.

Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд үүрэг өгсөн 14 хуулийн 26 заалт, Улсын Их Хурлын 13 тогтоолын 25 заалт, Эдийн засгийн байнгын хорооны 5 тогтоолын 21 заалт бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлсэн байна.

Хууль тогтоомж	Тоо	Заалтын тоо	Хавсралтын дугаар
Монгол Улсын хууль	14	26	1
Улсын Их Хурлын тогтоол	13	25	2
Байнгын хорооны тогтоол	5	21	3

ЗУРГАА. САНАЛ

1/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ хийж, үнэлээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулан тайлбарлаагүй, хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлсэн байна.

2/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2015 онд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтаа дахин ирүүлсэн байна.

4/ Мэдээллийн сангийн хяналтаас хасах саналтай Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бүрэн хэрэгжсэн хууль тогтоомжийн нийт 28 хуудас жагсаалтыг хавсаргав.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Жолоочийн даатгалын тухай 2011.10.06	22.3. энэ хуулийн 22.1.2, 22.1.4-т заасан эх үүсвэрийг жолоочийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	"Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх журам" Сангийн сайд, Зам, тээврийн сайдын 2013.01.13-ны өдрийн №20/19 хамтарсан тушаалаар батлуулан, Хууль зүйн яамны 2013.02.06-ны өдрийн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлийн №3367 дугаарт бүртгэгдсэн.
2	Хаягжуулалтын тухай 2013.02.07	4.6.хаягийн тэмдэглэгээний стандартыг газрын харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	2016 онд Стандартчилал, хэмжил зүйн газар "Нэгдсэн хаягжуулалт, хаягийн бичвэрт тавих шаардлага MNS 6275:2016 стандартыг баталж, мөрдүүлж байна. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор "Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг баталсан. Хаягжуулалтын ажлын хүрээнд "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5283:2014 стандартыг боловсруулан бүх яамдууд болон холбогдох агентлаг, байгууллагуудаас санал авч тусган Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014.02.27-ны өдрийн 01-р тогтоолоор баталгаажуулсан.
		4.7.гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.	Хуульд заасны дагуу журмын төслийг боловсруулж, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлуулсан.
3	Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга/ 2015.02.12	22.3 чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.	Газрын төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 152 дугаар тогтоолд нэмэлт оруулж Чөлөөт бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг тогтоосон болно.

		8.4.чөлөөт бүсийн захирагч ажлын албатай байх бөгөөд уг ажлын албаны бүтэц, орон тоо, зардлын хязгаарыг Засгийн газар тогтооно.	2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Засгийн газрын 126 дугаар тогтоолоор "Алтанбулаг", "Замын-Үүд", "Цагааннуур" чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батласан болно.
4	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015.06.19	5.1.5. Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг гаргах судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах	Засгийн газрын 2015 оны 360 дугаар тогтоолоор “Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг тооцоолохтой холбогдох зардлыг санхүүжүүлэх журам”-ыг батлуулсан.
5	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай 2015.06.26	7.1.2. Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тэргүүлэх ач холбогдол бүхий улсын төсвөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг батлах;	“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-ний төслийг НЗДТГ-тай хамтран боловсруулж, Засгийн газрын 2016.03.28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдэн, 174 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус төлөвлөгөөнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан болно. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016- 2020 оны төлөвлөгөө”-нд нийцүүлэн нийслэлийн 2017 оны хот байгуулалтын төсөл, арга хэмжээний төсвийг баталж, тус төсөвт Улаанбаатар хотод дахин хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэхээр тусгасан болно. Тухайлбал, дахин төлөвлөлтийн байршлуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажилд 493,5 сая төгрөг, гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн шугам сүлжээ, авто замын зураг төсөл, угсралтын ажилд 11,413,1 сая төгрөг, газар дахин зохион байгуулах төсөл хэрэгжүүлэхэд 2,170,1 сая төгрөг, Гандан орчмын гэр хорооллыг аялал жуулчлал, түүхэн өв соёлын төв болгон хөгжүүлэхэд 1,000,0 сая төгрөг, Багатойруу орчмын хуучин барилгуудыг буулгах оновчтой

			<p>төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх инженерийн шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажилд 124,6 сая төгрөг зарцуулахаар тусгасан.</p>
		<p>8.1.7. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загварыг батлах.</p>	<p>Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор БХБ-ын сайдын 2015.10.19-ний өдрийн 195 дугаар тушаалаар Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдаж батлагдах дүрэм, журам, заавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажилласан.</p> <p>“Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”-ын хүрээнд</p> <p>“Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”,</p> <p>“Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”,</p> <p>“Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг БХБ-ын сайдын 2016.07.05-ны өдрийн 125 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлийн 3658 дугаарт бүртгүүлсэн.</p> <p>Тус тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Газрын харилцаа, геодези, зураг зүйн газарт 2016.07.22-ны өдрийн 02/ 1958 тоот, Барилгын хөгжлийн төвд 2016.07.22-ны өдрийн 02/ 1959 тоот албан бичиг тус тус хүргүүлсэн.</p>
6	<p>Үйлдвэрлэлийг дэмжих тухай</p> <p>2015.07.09</p>	<p>11.2.үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.</p>	<p>“Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд улсын төсвөөс 2016 онд 5,0 тэрбум төгрөг хуваарилагдсан.</p> <p>Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсвийн сарын хуваарийг хийж, Аж үйлдвэрийн сайдад танилцуулан хуулийн хугацаанд СЯ-д хүргүүлэн, Сангийн сайдын</p>

			тушаалаар батлуулав. 2016 оны Төсвийн тодотголтой холбогдон төсөвт буцаан татагдсан. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ХХААХҮ-ийн салбарын чиглэлээр арга хэмжээнд тусгагдсан. 2018 оноос төсөвт 3 тэрбум төгрөг тусгасан.
		14.3.үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн тухайн жилийн төсвийн хуваарийг аж үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Засгийн газрын 2016 оны “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 193 дугаар тогтоолын дагуу үйлдвэрлэлийг хөгжүүлэх санд улсын төсвөөс 2016 онд 5,0 тэрбум төгрөг хуваарилагдсан. Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн төсвийн сарын хуваарийг хийж, Аж үйлдвэрийн сайдад танилцуулан хуулийн хугацаанд СЯ-д хүргүүлэн, Сангийн сайдын тушаалаар батлуулав. 2016 оны Төсвийн тодотголтой холбогдон төсөвт буцаан татагдсан. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ХХААХҮ-ийн салбарын чиглэлээр арга хэмжээнд тусгагдсан. 2018 оноос төсөвт 3 тэрбум төгрөг тусгасан.
		6.1.3. Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавихтай холбоотой журмыг батлах;	Засгийн газрын 2016 оны “Дэмжлэгт хамрагдах үйлдвэрлэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тооцох, дэмжлэгийг олгох, хяналт тавихтай холбоотой журам”-ыг 193 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан.
7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай 2015.07.09	10.1.2. чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг шалгаруулахыг хориглоно. Энэ хуулийн 10.11-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталсан.

8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай 2015.07.09	101.2.Энэ хуулийн 101.1-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор дотоодын үйлдвэрээс худалдан авах 101 барааны жагсаалтыг баталсан.
9	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015.11.26	20.2.энэ хуулийн 7-16 дугаар зүйлд заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх журам”-ыг батлан мөрдүүлж байна.
	22.4.энэ хуулийн 22.2-т заасан эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, 22.3-т заасан мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус батална.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журмын төслийг боловсруулж, Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулав. Мөн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх журам болон Салбаруудын хөгжлийн жил бүрийн эмхэтгэлийг боловсруулах, түүнийг хэвлэн нийтлэхэд баримтлах журмын төслүүдийг тус тус боловсруулж байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 22.2, 22.3 дахь хэсэгт 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдөр өөрчлөлт орсноор эмхэтгэлийг боловсруулж, хэвлэн нийтлэх, мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг боловсруулах ажлууд нь Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад чиг үүрэгт шилжсэн. 2016 оны 10 дугаар сарын 12-ны 01/120 тоот албан бичгээр бүх яамдад салбарын танилцуулгыг эцэслэн байдлаар хүлээн авах тухай албан бичиг илгээсэн. Танилцуулгад дүн шинжилгээ хийж, хэвлүүлсэн.	
	22.5 үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөгжлийн бодлого төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичигт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд салбаруудын зорилт, арга хэмжээг тусган боловсруулж байна. Олон Улсын 20 гаруй байгууллагуудын төлөөлөл	

		<p>бодлогын баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхийг бэхжүүлэхэд холбогдох байгууллагад дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>оролцсон “Хөгжлийн бодлогын зөвлөл Тинк Танк /think tank/”-ын зөвлөлдөх уулзалтыг 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Уулзалтад олон улсын 34 байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцож хэлэлцүүлэг хийсэн. Олон Улсын Санхүүгийн Корпорацтай хамтран ажиллах санамж бичгийг 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан. Мөн хамтран ажиллах санамж бичгийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдөр батлуулсан. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ийн “Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага /ЭТИС/ хөтөлбөртэй хамтран “Тогтвортой хөгжлийн үндэсний форум-2016” уулзалтыг 2016 оны 11 дүгээр сарын 17-ний өдөр зохион байгуулж Хөгжлийн бодлого төлөвлөлт болон, Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын талаар илтгэл тавьсан. Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт /ТХЗ/-ууд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /ТХҮБ/-ын зорилтуудыг танилцуулах, хэрэгжүүлэх чиглэлээр уулзалт, хэлэлцүүлэг, сургалт, семинарууд зохион байгуулав. “Монгол Улсын Засгийн газар - Хөгжлийн түншүүдийн зөвлөлдөх уулзалт” 2016 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус зөвлөлдөх уулзалтын тараах материалд салбаруудын танилцуулгыг яамдаас авч нэгтгэн боловсруулсан. Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт санал хүргүүлж Эдийн засгийг сэргээх хөтөлбөр батлагдсан. Гадны байгууллагуудтай хамтран ажиллах Дунд хугацааны стратеги, төлөвлөгөөний төсөлд санал боловсруулах, хэрэгжүүлэх зорилгоор Олон Улсын 20 гаруй байгууллагуудын давхардсан тоогоор 109 төлөөлөгчийг хүлээн авч уулзсан.</p>
		<p>6.6. Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газар батална.</p>	<p>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмыг Засгийн газрын 2016 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 249 дүгээр тогтоолоор батлав.</p>

10	<p>Эрчим хүч хэмнэлтийн тухай</p> <p>2015.11.26</p>	<p>5.1.3 энэ хуулийн 9.1.9-т заасан журам батлах.</p>	<p>“Эрчим хүчний аудит хийх журам”, “Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”, “Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журам”, “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлагнах журам”-ын төслийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл, мөн “Үүрэг хүлээсэн хэрэглэгч”-ээр тодорхойлоход тавигдах хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээг тогтоох тухай ЗГ-ын тогтоолын төсөлд газруудаас санал авсан ба 2016.04.28-ны өдөр дээрх Засгийн газрын тогтоолуудыг хэлэлцэх уулзалтыг холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан ЭХЯ-нд зохион байгуулан санал шүүмжийг тусгасан.</p> <p>Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газрын 2016 оны 295 дугаар тогтоолоор батлуулсан.</p>
		<p>6.1.3. Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийг эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх.</p>	<p>Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх 2016-2018 оны календарчилсан төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p>
		<p>9.1.9. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө, боловсруулах аргачлал, тайлагнах журам;</p>	<p>“Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал, тайлагнах журам”-ын төслийг боловсруулж 2016.05.31-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.</p>
11	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай</p> <p>2015.11.26</p>	<p>2/65.1 “1.төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан тухай бүр хувьчлалыг эрхлэн явуулсан этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Тайлан бичих загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”</p>	<p>Засгийн газрын 2015.08.17-ны өдрийн 336 тоот тогтоолоор баталсан.</p>

12	Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ 2016.01.29	44.2.барилгын салбарын ажилтны тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг төрийн захиргааны байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл хариуцна. Зөвлөлийн дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан хуулийг даган гарах дүрэм, журмыг шинэчлэх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2015.04.30-ны өдрийн 91 дүгээр тушаалаар баталсан “Инженерийн мэргэжлийн төрлөөр орон тооны бус мэргэжлийн зөвлөл ажиллуулах дүрэм”-д өөрчлөлт оруулах шаардлага бий болсныг үндэслэн “Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам”-ыг боловсруулж, БХБС-ын 2016.09.27-ны өдрийн 160 дугаар тушаалаар батлуулсан.
ЗГХЭГ-аас нийт 14 хуулийн 26 заалтыг хяналтаас хасах саналтай ирүүлсэнд хяналт шинжилгээ хийгээд 12 хуулийн 21 заалтыг хасах саналтай байна.			

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p align="center">Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай</p> <p align="center">2010.06.24 №:32</p>	<p>2.Эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтцийг төмөр замын тээврийн тухай хуулийн 6.2-т заасны дагуу төрийн өмчид байлгах;</p> <p>4. Даланзадгад - Таван толгой - Зүүнбаян, Сайншанд- Баруун - Урт -Чойбалсан чиглэлд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг 2010 онд багтаан эхлүүлэх;</p>	<p>“Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай” хуулийн төсөлд эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой шинээр барих төмөр замын суурь бүтэц төрийн өмчийн болон төрийн өмчийн давамгайлсан хуулийн этгээдийн өмчлөлд байлгахгаар тодорхой зааж оруулсан. Мөн төмөр замын асуудлаар Засгийн газраас гарах тогтоолын төсөлд энэ үзэл баримтлалыг баримтлах талаар санал оруулж байна.</p> <p>Шинэ төмөр зам төслийн техник, санхүү, хуулийн зөвлөхийг шалгаруулж, хуулийн зөвлөхөөр шалгарсан АНУ-ын “Sidley Austin” LLP болон дотоодын “MDS Associates” ХХК хамтарсан түншлэлтэй МТЗ-ЗҮ-2013-01 тоот гэрээг 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдөр, Техникийн зөвлөхөөр шалгарсан Япон улсын “Nippon Koei” компанитай 2013 оны 5 дугаар сарын 14-ний өдөр, Санхүүгийн зөвлөхөөр шалгарсан Франц улсын “BNP Paribas” болон АНУ-ын “Guggenheim International” ХХК хамтарсан түншлэлтэй 5 дугаар сарын 24-ний өдөр тус тус гэрээт ажлыг эхлүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд Ухаахудагийн уурхайгаас Гашуунсухайтын чиглэлийн төмөр замын чиг болон түүний дагуух зурвас газрыг тогтоох тухай асуудлыг Засгийн газраар хэлэлцүүлэн 2014 оны 81, 91 дүгээр тогтоолыг гаргуулж ажилласан.</p> <p>Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажил нийт 51.84%-тай, гүүрийн ажил 65.76%, хоолойн ажил 63.70%, газар шорооны ажил 86.6%-тай байна.</p> <p>Тавантолгой-Сайншанд-Хөөт-Бичигт-Чойбалсан чиглэлийн төмөр замын техникийн зураг төсөл болон тендерийн бичиг баримтыг Nippon Koei компани 100% хийж гүйцэтгэн “Монголын төмөр зам” ТӨХК-д хүлээлгэн өгөөд байна. Санхүүжилтийн асуудлаас болоод тендер зарлагдаагүй байна.</p>

			<p>Хөөт-Бичигтийн чиглэлд барих төмөр зам дээр “Монголын төмөр зам” ТӨХК БНХАУ-ын “Бай-шинь төмөр зам” компанитай хамтран 51%, 49%-тай төсөл хэрэгжүүлэхээр 2015 оны 5 дугаар сард Санамж бичиг байгуулж, гарын үсэг зурсан.</p> <p>Хөөт-Бичигт, Хөөт-Нөмрөгийн чиглэлд төмөр зам барих урьдчилсан ТЭЗҮ болон БОНУ-ний ажлууд хийгдэж байна. Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ 2015 оны 8 дугаар сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеээр Японы тал Тавантолгой-Сайншанд, цаашлаад Сайншанд-Хөөт-Чойбалсан-Эрэнцав чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад оролцох сонирхолтойгоо илэрхийлж, хоёр тал хамтран ажиллах эрмэлзлээ нотолсон харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.</p>
2	<p>Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай</p> <p>2010.07.07 №:39</p>	<p>1.2.г. “Монгол Улсын 2012 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай, хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолын 1 дэх заалтын 9 дэх дэд заалтын дагуу Засгийн газар иргэдээс худалдаж авсан хувьцааны тоогоор энэ тогтоолын 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “в” заалтад заасан хувь, хэмжээг нэмэгдүүлэн тогтоох.</p>	<p>2012 оны Төсвийн тухай хууль батлагдснаар хэрэгжиж дууссан.</p>
3	<p>Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай</p> <p>2012.09.18 №:37</p>	<p>2.1 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулж байх</p>	<p>Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолоор 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг УИХ-д хүргүүлэн ажиллав.</p>

4	<p>Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>2013.01.10 №:06</p>	<p>1/банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг эхлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай: 1/хадгаламжийн даатгалын корпорацийг банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасны дагуу 2013 оны 02 дугаар сарын 10-ны дотор байгуулах;</p>	<p>Хадгаламжийн даатгалын корпорацийг Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасны дагуу тухайн үед нь байгуулсан.</p>
5	<p>Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай</p> <p>2013.05.24 №:41</p>	<p>1/үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардлагатай сургалт, сурталчилгааг тодорхой хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх;</p> <p>3/хөрөнгийн биржийн бүртгэлийн шалгуур хангахгүй байгаа хувьцаат компанийг хөрөнгийн биржийн бүртгэлээс хасах, татан буугдсан хамтын сан болон хөрөнгө оруулалтын сангийн үлдэгдэл хөрөнгийн асуудлыг хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашигт нийцсэн хэлбэрээр</p>	<p>Хөрөнгийн биржид хэрэглэгдэж байгаа “Мянганы мэдээллийн технологи систем (Millennium IT systems)-д нэмэлт өөрчлөлт оруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэв. Түүнчлэн, дараах сэдвээр холбогдох сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>Хөрөнгийн биржийн арилжаа, хоорондын тооцоо ба гүйлгээ, хадгаламжийн үйл ажиллагаа явуулах дэд бүтэц бүрдүүлэлт, мянганы мэдээллийн технолог (ММТ)-ийн хэрэглээ, Засгийн газрын бондын арилжаа ба зах зээл, компанийн бондын арилжаа, түүний богино, дунд, урт хугацаан дахь хүртээмж ба бондын өгөөжийг тодорхойлох, хөрвөх чадавхи, төлбөр гүйцэтгэх чадавхи бүрдүүлэлт, ил тод байдал хангалт, хоёр дахь зах зээлийн үйлчилгээ ба анхдагч захад хөрөнгө оруулалтыг нийтэд санал болгох, хөрөнгө босгох үйлчилгээ үзүүлэх горим, хөрөнгийн захад санхүүгийн болон бараа бүтээгдэхүүний арилжааг ирээдүйн нөхцөлт фүчерз, опцион гэрээгээр явуулах болон хүүгийн солилцоо хийхэд үүсмэл хэрэгсэлийг ММТ ашиглан хэрэглэх, Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанид хяналт тавих, шалгалт хийх горим зэрэг хамаарна.</p> <p>Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн 2014 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 7-1/3741 тоот “Бүртгэлийн журам шинэчлэн батлах тухай” тогтоолын 3.2-т “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д одоо бүртгэлтэй байгаа компаниудыг арилжааны түүх, идэвх, зах зээлийн үнэлгээ, хувьцааны олон нийтийн эзэмшлийн хувь санхүүгийн байдал, хууль болон гэрээгээр хүлээсэн үүргийн</p>

		шийдвэрлэх;	хэрэгжилтийн байдал зэргийг нь харгалзан тодорхой ангилалд түр хугацаанд оруулах, 3.3-т заасан түр бүртгүүлсэн компаниуд 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор “Бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр бүлэгт заасан зохих ангиллын шалгуурыг хангаагүй тохиолдолд ангилал бууруулах буюу бүртгэлээс хасах арга хэмжээ авч ажилласан.
		6/ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээдийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах ажлыг 2013 онд багтаан зохион байгуулах.	"Багануур" ХК-ийн 25 хувь, "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцааны 10 хувийг Монголын Хөрөнгийн бирж дээр арилжаалж байна. Стратегийн ордын төрийн эзэмшлийн хувийг "Эрдэнэс МГЛ" ХХК-д эзэмшүүлэх ажил хийгдсэн. Тухайлбал: Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 51%, Оюутолгой ХХК-ийн Монголын талын 34% хувь, Мон-Атом ХХК-ийн 100%, Гашуунсухайтын авто зам ХХК-ийн 100%, Багануур ХК-ийн төрийн эзэмшлийн 75%, Шивээ-Овоо ХК-ийн 90%
6	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого батлах тухай 2014.01.16 №:18	2."төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай: 1/"төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн эрдэс баялгийн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, батлуулан хэрэгжүүлэх; 2/"төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, төрийн мөнгөний бодлого, дунд, урт хугацааны төлөвлөлтөд тусгуулан хэрэгжүүлэх.	1. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын зарчим, зорилтод нийцүүлэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн УИХ-ын чуулганаар батлуулсан. 2. "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-д тусгасан зорилт, чиглэлийг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл болон урт, дунд хугацааны хөтөлбөрт тухай бүр тусган ажиллаж байна.
7	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах	2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай тогтоолыг хэрэгжүүлэн тухайн үед нь ажилласан.

	<p>тухай</p> <p>2014.07.01 №:54</p>	<p>2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.</p>	
		<p>3. “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан хэрэгжилтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авч, түүний биелэлтийн явцыг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.</p>	<p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай тогтоолын хэрэгжилтийг тухайн үед нь хэрэгжүүлэн ажиллаж, одоогоор өөр үндсэн чиглэл хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>
<p>8</p>	<p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай</p> <p>2014.11.13 №:69</p>	<p>2.4 Монгол Улсын төсвийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл боловсруулахад ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн төсөөллийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн боловсруулах;</p>	<p>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолыг тухайн үед нь хэрэгжүүлэн ажилласан болно.</p>
<p>9</p>	<p>Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай</p> <p>2015.02.17 №:36</p>	<p>2/ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа хуулийн этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр худалдах, худалдан авах замаар хөрөнгийн зах зээлд оролцох, санхүүжилт босгох зорилтыг хэрэгжүүлэх, олон улсын хөрөнгийн зах зээлд Монгол Улсын нэр хүндийг өсгөх боломжийг судалж хэрэгжүүлэх;</p>	<p>"Багануур" ХК-ийн 25 хувь, "Шивээ-Овоо" ХК-ийн хувьцааны 10 хувийг Монголын Хөрөнгийн бирж дээр арилжаалж байна.</p> <p>Стратегийн ордын төрийн эзэмшлийн хувийг "Эрдэнэс МГЛ" ХХК-д эзэмшүүлэх ажил хийгдсэн. Тухайлбал: Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн 51%, Оюутолгой ХХК-ийн Монголын талын 34% хувь, Мон-Атом ХХК-ийн 100%, Гашуунсухайтын авто зам ХХК-ийн 100%, Багануур ХК-ийн төрийн эзэмшлийн 75%, Шивээ-Овоо ХК-ийн 90%</p>

	<p>3/гол нэр төрлийн эрдэс баялгийн үйлдвэрлэлийн биет хэмжээг тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл болон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн санал, тухайн салбарын урт, дунд хугацааны үйлдвэрлэлийн төлөвлөгөөний төсөөлөлд үндэслэн тооцоолдог аргачлалыг боловсруулж мөрдүүлэх, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах чиглэлээр нөөц бололцоогоо бүрэн дайчлах;</p>	<p>Гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүнийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлж, орлогын төсөөллийг мөн хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу тооцож байна.</p> <p>Орлогын төсөөллийг мэргэжлийн байгууллага болон Уул уурхайн яам, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар болон гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн олборлож буй аж ахуйн нэгжүүдээс албан ёсоор мэдээлэл авч боловсруулж байгаа болно.</p> <p>Гол нэр төрлийн бүтээгдэхүүний орлогын төлөвлөх, түүнээс Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх журмыг Сангийн сайдын 2013 оны 27 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.</p> <p>Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлт 2015 оны байдлаар 98.4 хувьтай гарсан.</p> <p>2016 оны эхний 5 сарын байдлаар нүүрс 9.7 сая тонн, алт 4.4 тн, газрын тос 500.7 мянган тонныг тус тус олборлоод байна. Хайлуур жоншны баяжмал 72.0 мянган тонн, зэсийн хүдрийн баяжмал 619.7 мянган тонн, төмрийн хүдрийн баяжмал 1.5 сая тонн, цайрын баяжмал 36.5 мянган тонныг тус тус үйлдвэрлэсэн байна.</p> <p>2016 оны эхний 5 сарын байдлаар 697.7 мянган тонн зэсийн баяжмал, төмрийн хүдрийн тухайд 1.9 сая тонн, алт 5.2 тн, нүүрс 7.2 сая тонн, газрын тос 484.7 мянган тонныг тус тус экспортлосон ба Эрдэс баялгийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс 2016 оны эхний 5 сарын байдлаар 302.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлсэн ба газрын тосны газраас 45.0 тэрбум төгрөг, Ашигт малтмалын газраас 15.2 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна. Сангийн яам, Уул уурхайн яам, Гааль, Татварын ерөнхий газар болон АМГ-тай хамтран гол нэрийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг эрэлт, нийлүүлтэд тулгуурлан үндэслэлтэй боловсруулах чиглэлээр ажиллаж байна.</p>
	<p>4/улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт барьсан болон барьж байгаа худалдааны төвүүдийн барилгын ажлыг дуусгаж, хувийн хэвшилд худалдаж, орлогыг нь улсын төсөвт төвлөрүүлэх;</p>	<p>2015 онд улсын төсвөөс "Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд 409.6 сая төгрөг, "Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/"-д 465.9 сая төгрөг, "Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/"-д 217.7 сая төгрөгийн</p>

			<p>санхүүжилт тус тус олгосон. Хөвсгөл суманд баригдаж байгаа худалдааны төвийн барилга ашиглалтад ороогүй. Гэвч 2015 онд төсвийн орлогын бүрдэлтээс хамаарч дээрх 2 барилгын санхүүжилтийг дутуу олгосон бөгөөд дутуу санхүүжилтийн асуудлыг векселиэр олгохоор төлөвлөж Засгийн газрын 2016 оны 72 дугаар тогтоолоор санхүүжилтийг шийдвэрлэсэн.</p> <p>Сэлэнгэ аймгийн Худалдааны төвийн барилгын гүйцэтгэгч компани "Өсөх-Урам" ХХК-д 2016 оны 2 дугаар сард Векселиэр 295.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Хүнс, худалдааны төвийн барилгын гүйцэтгэгч "Ган" ХХК-д Засгийн газрын 2016 оны 72 дугаар тогтоолын дагуу 535.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.</p> <p>Улсын төсвөөс 2016 онд тухайн төсөл, арга хэмжээнд 395.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 558.2 сая төгрөг батлагдаж барилгыг 2017 онд дуусгах төлөвлөгөөтэй байна.</p> <p>2015 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/ арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжүүлэн, үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон.</p> <p>Дээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/-81%, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/-100%, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-100%, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/-70%-тай байна. Аж үйлдвэрийн сайдын багцын Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант/, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/ 4</p>
--	--	--	--

			арга хэмжээг Төсвийн хуулийн 14.4 дэх заалтын дагуу Аж үйлдвэрийн сайдын тушаалаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэн, 1360,8 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгосон байна.
		5/нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн менежментийг боловсронгуй болгож, уг сангийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах;	2015 оны байдлаар 487,0 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулан ажиллаж байна. Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод 51,1 тэрбум төгрөг, харилцах дансны хүүгийн орлогод 4,5 тэрбум төгрөг, Засгийн газрын үнэт цаасны хүүгийн орлогод 5,3 тэрбум төгрөгийг тус тус нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн. 2016 оны байдлаар нийт 9 арилжааны банкинд 583,0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан. Засгийн газрын үнэт цаас 57 тэрбум төгрөгөөр авч хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33 тоот тогтоолын дагуу 2016 оны 12 сарын 26-наас нэмэлт гэрээ байгуулагдан хадгаламжийн хүүг 15 хувь болон түүнээс дээш хувиар өөрчилсөн. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголбанкттай хамтран олон нийтэд мэдээлсэн.
10	Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2016 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай 2015.11.13 №:103	2.өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн 0-18 хүртэлх насны хүүхдэд хүүхдийн мөнгө олгох журам баталж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар/Ч.Сайханбилэг/-т даалгасугай. /энэ заалтад 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 07 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/	УИХ-ын 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 07 тогтоолоор өрхийн амьжиргааны түвшин тогтоолгох судалгаанд хамрагдсан нийт өрхийн 0-18 насны бүх хүүхдэд хүүхдийн мөнгийг олгохоор шийдвэрлэсэн. 2016 оны 6 дугаар сарын гүйцэтгэлээр 122,6 тэрбум төгрөгийг 1,021,500 хүүхэд тус бүрийн нэрийн дансанд шилжүүлсэн.
11	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах	1/үндэсний аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан дутуу хэрэгжсэн болон хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгааныг тодорхой болгож, хэрэгцээ, шаардлага, хөрөнгийн эх үүсвэрийг харгалзан эрэмбэлж, хэрэгжүүлэх боломжтой зорилт, арга хэмжээг 2016 оны	Хэрэгжилтийг ханган ажилласан.

	<p>зарим арга хэмжээний тухай</p> <p>2016.05.13 №:05</p>	<p>үндсэн чиглэлтэй хамтатган хэрэгжүүлэх арга хэмжээ авах;</p>	
		<p>2/үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн төлөвлөлт болон санхүүжилтийн бусад эх үүсвэртэй уялдуулж, тухайн жилд хэрэгжих боломж, бодит байдлыг харгалзан зорилт, арга хэмжээ бүрийн хүрэх түвшин, түүний биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, үргэлжлүүлэн санхүүжүүлэх зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дараа жилийн төсвийн тухай хуульд нэмж тусгаж байх;</p>	<p>“Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн төслийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох яамд, агентлагуудаас ирүүлсэн зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгаж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн уялдуулж, шаардагдах хөрөнгийн хэмжээг Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоолоор батлуулав.</p>
		<p>3/ үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдөх;</p>	<p>Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ үнэлгээний нийтлэг журмыг баримталж байгаа бөгөөд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”-ийн 20.2 заасны дагуу “Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулсан.</p>
		<p>4/ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоол, эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд үндэсний аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн биелэлтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах нийтлэг журам”-ыг батлуулан мөрдөж байна. Мөн “Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн батлуулсан.</p> <p>Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг боловсруулах ажлын хүрээнд холбогдох яамд, агентлагуудаас ирүүлсэн зорилт, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгаж, шаардагдах хөрөнгийн хэмжээг Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлэн</p>

			боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолоор батлуулсан.
12	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014.04.17 №:30	1.12/ нийслэлд болон нийслэлийн ойролцоо байрлалтай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангийн барилга байгууламж, Архивын ерөнхий газрын 2 дугаар байр, Хууль зүйн яамны байр, шүүх, прокурорын барилга байгууламжийг тэдгээрийн тус тусын эзэмшил газрын хамт зохих хууль тогтоомжийн хүрээнд худалдан бүрлуулах замаар орлого бүрдүүлэн, уг орлогоос нэгдсэн хорих, шүүх, прокурорын байгууллагын цогцолбор, архивын шинэ байр болон хууль зүйн салбарын үйлчилгээг төвлөрүүлэх барилга байгууламжид хөрөнгө оруулалт хийх ажлыг зохион байгуулах	2015 онд төсвийн орон тоог нийт 3083 байхаар хянуулж, УИХ-ын 2014 оны 30 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг үндэслэн нийт 21 орон тоо хасагдаж, цалингийн зардалд нийт 32619,0 сая төгрөгийг батлуулсан. Төсвийн хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу төсвийн шууд захирагчдын орон тооны дээд хязгаарыг ЗГ-ын 2014 оны 387 дугаар тогтоолын дагуу тооцож Ерөнхий газрын даргын 2015 оны А/35 дугаар тушаалаар батлан, албан тушаал, зэрэглэл тус бүрээр баталгаажуулан харьяа байгууллагуудад хүргүүлсэн. “Дуудлагын худалдаагаар худалдах төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2014 оны 188 дугаар тогтоолын хавсралтаар Архивын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг баталсан билээ. Засгийн газрын 2015 оны 44-р тогтоолоор уг жагсаалтын 2, 4-6, 8 дахь хэсэг, 2016 оны 51 дүгээр тогтоолоор жагсаалтын 9 дэх хэсэг, 2016 оны 127 дугаар тогтоолоор жагсаалтын 1, 3, 7 дахь хэсгийн заалтыг тус тус хүчингүй болгосон.
		1.6/төсөвт ертгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэхэд нөлөөлсөн зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 18, 181 дүгээр тушаалыг хүчингүй болгох арга хэмжээ авах, барилгын норм, нормативын баримт бичгийг батлахтай холбоотой барилгын тухай хуулийн холбогдох заалтыг өөрчлөх талаар хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх,	Барилгын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлуулсан. Хуулийг дагаж мөрдөх журмуудыг боловсруулж байна. Эдгээр дүрэм, журам, норм нормативын баримт бичгүүд батлагдсанаар дээрх шийдвэрүүд хүчингүй болно.

		1.7/ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртгийн тооцооллыг алдаатай боловсруулсан 6 дугаар хавсралтад нэр нь дурдагдсан төсөвчдөд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох,	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртгийн тооцооллыг алдаатай боловсруулсан 6 дугаар хавсралтад нэр нь дурдагдсан төсөвчдөд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэхээр барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын хэсэг байгуулсан. Иймд уг заалтын хэрэгжилтийг мэргэжлийн яам нь хариуцан хяналт тавина.
13	Хөдөө аж ахуйн “халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай 2016.05.19 №: 46-16-05	1/хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай	ХХАА-н Сайдын 2016 оны А-91, А-110 тоот тушаалуудаар Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулан орон тооны бүтцийг тогтоож, шаардлагатай санхүүжилтийг ХХААХҮ-н Сайдын багцаас санхүүжүүлэн үйл ажиллагаа явуулж байна.
Нийт 13 тогтоолын 25 заалтыг хяналтаас хасах саналтай ирүүлсэн болно.			

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолийн нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	<p>Автозам, гүүрийн барилга угсралтын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай</p> <p align="center">2011.11.23 №:23</p>	<p>1.1 авто замын зураг төсвийн ажилд хяналт тавьж, магадлал хийдэг одоогийн бүтцийг өөрчилж, мэргэжлийн байгууллагын үүрэг хариуцлага, зураг төсвийн чанарыг дээшлүүлж, авто зам, гүүрийн барилга угсралтын ажилд тавих технологийн хяналтыг хөндлөнгийн зөвлөх компаниар гүйцэтгүүлж байх тогтолцоог 2012 оноос эхлэн бүрдүүлэх</p>	<p>2011 оны Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны тогтоолын дагуу шинээр баригдах зам, гүүрийн барилгын ажлын чанарыг сайжруулах зорилгоор хөндлөнгийн хяналтын багаар гүйцэтгүүлэхээр Засгийн газрын хуралдаанд танилцуулж, улмаар Засгийн газрын 2012 оны 47, 106, 143, 124 дүгээр тогтоолуудыг батлуулан тус тогтоолуудаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдсэн Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж байгаа зам, гүүрийн ажлуудыг Зөвлөх багаар хянуулан гүйцэтгүүлж байна.</p> <p>Засгийн газрын 2015 оны 55 дугаар тогтоол, ТӨХ-ны 2015 оны 220 дугаар тогтоолын дагуу "Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан. Шинэ дүрмийн хүрээнд "Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, хүлээн авах журам"-ыг боловсруулан ЗТЯ-ны ТНБД-ын 2015 оны 189 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Мөн ЗТХТ-ийн захирлын 2015 оны 45 дугаар тушаалаар "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам", 46 дугаар тушаалаар "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх экспертийн ажиллах журам", 52 дугаар тушаалаар Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх</p>

			<p>экспертүүдийг өрсөлдөөний журмаар зохион байгуулж, санал, дүгнэлт гаргах байнгын комиссыг байгуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p>
		<p>1.2 авто зам, гүүрийн барилга угсралт, засварын ажлын төсөвт өртөг нь зах зээлийн бодит үнэ ханш, инфляцтай нягт уялдаж байх зарчим, аргачлалыг замын ажлын гэрээ хэлцэл, санхүүжилтийн арга, хэлбэрт тууштай нэвтрүүлж, автозам, гүүрийн хийц бүтээц хийхэд зориулан газар дээр нь татаж нөөцөлсөн цемент, арматур, битум, ган хийц, хүчний ган тросс, тулах хэсэг, 20 тонноос дээш хэмжээний шатахуун зэрэг гадаад материал болон бэлтгэж буталсан чулуу зэргийг тоо хэмжээгээр нь санхүүжүүлэх замаар зам, гүүрийн ажил эрхэлдэг компаниудын үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг дэмжих арга хэмжээг 2011 оны 12 дугаар сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэх</p>	<p>Улсын төсөв, Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй авто зам, гүүрийн барилгын ажилд ашиглагдах бараа, материал, хийц бүтээцүүдэд гүйцэтгэл гаргах, гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг боловсруулан Сангийн сайд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар журмын төслийг танилцуулга бусад материалуудын хамтаар 2012 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн боловч санхүүжилтийн журмыг шинэчлэн батлахдаа тухайн асуудлыг судлан шинэ журамд тусгах талаар Сангийн яамны холбогдох албан тушаалтнууд мэдэгдсэн боловч одоо болтол ажил хэрэг болоогүй байна.</p> <p>Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зам барилгын төсөл хөтөлбөрүүдийн хувьд талбайд татаж нөөцөлсөн бараа материал болох арматур, цемент, битумын тоо хэмжээг нягталж үзэж, хяналтын зөвлөх нь баталгаажуулан гүйцэтгэлээр оруулж ирсэн тохиолдолд санхүүжилт олгох боломжийг Хөгжлийн банктэй тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэсэн. 2013 онд хэрэгжүүлсэн зам барилгын ажлын явцад талбайд татсан бараа материалыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болно.</p>
2	<p>"Түлш эрчим хүчний салбарын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2015.02.05</p>	<p>1.1 эрчим хүчний салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төслүүд, эрчим хүчний тухай, сэргээгдэх эрчим хүчний тухай, өрсөлдөөний тухай хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж</p>	<p>Эрчим хүчний салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын баримт бичиг, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төсөл, Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулж УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар</p>

		Улсын ИХ Хурлын 2015 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх.	хэлэлцүүлж, 63 дугаар тогтоолоор батлуулсан.
		1.3 эрчим хүчний салбарын менежментийг сайжруулах, зах зээлийн загварыг боловсронгуй болгох	“Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуульд эрчим хүчний салбарын институт хоорондын харилцан уялдаа, балансыг хангах зохицуулалтыг тусгаж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй үүсэх харилцааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх, цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахтай холбоотой үүсэх харилцаануудыг зохицуулж, салбар үр ашигтай, арилжааны хэлбэрт суурилсан диспетчерийн нэгдсэн зохицуулалтыг хийж зах зээлийн зарчмаар ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлсэн.
		2.2 ахуйн хэрэглэгчдийн сар бүрийн 150кВтц хүртэл хэрэглээний төлбөрийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээших ахуйн хэрэглээ болон аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тариф болон эрчим хүчний нүүрсний үнийг бодит өртөгт хүргэх зохицуулалтыг төв, дорнод бүсэд 2015 онд багтаан, бусад бүсэд үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Ахуйн хэрэглэгчдийн сар бүрийн 150 кВтц хүртэл хэрэглээний төлбөрийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээших ахуйн хэрэглээ болон аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тариф болон эрчим хүчний нүүрсний үнийг бодит өртөгт хүргэх зохицуулалтыг хийсэн.
		2.3 эрчим хүчний үнэ тарифыг тооцохдоо чадлын тариф, ногоон тариф нэвтрүүлж, холболтын төлбөрийн тогтолцоог бий болгох	Эрчим хүчний үнэ тарифыг тооцохдоо чадлын тариф, ногоон тариф нэвтрүүлж, холболтын төлбөрийн тогтолцоог бий болгох арга хэмжээг авсан.
		2.4 шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийн цахилгаан эрчим хүч худалдах гарааны тарифыг тухайн төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, техникийн хүчин чадал, технологийн онцлог зэргийг харгалзан, хөрөнгө оруулалтын өгөөжийн зохих түвшинг хангасан байхаар тооцох	Шинээр барих эрчим хүчний эх үүсвэрийн цахилгаан эрчим хүч худалдах гарааны тарифыг тухайн төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, техникийн хүчин чадал, технологийн онцлог зэргийг харгалзан, хөрөнгө оруулалтын өгөөжийн зохих түвшинг хангасан байх чиглэлийг баримтлан ажиллаж байна.

		3 энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2016 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хурлын эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.	Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2016 оны эхний хагас жилд багтаан Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулсан.
3	Шалгалтын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2015.04.08 №:10	1.3 Монгол Улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани, консерцумаар гүйцэтгүүлэх;	"Монгол Улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-аас доошгүй хувийг үндэсний тээврийн компани гүйцэтгэж байна.
		1.4 "Эрдэнэс Таван толгой" ХК-ний ТУЗ-ийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхийг хянан шалгаж, хууль тогтоомж зөрчсөн төрийн албан хаагчдад хариуцлага тооцож хоиролыг барагдуулах арга хэмжээ авах;	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтын дүнг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулж, УИХ-ын зарим гишүүдээс гаргасан саналын дагуу ЭЗБХ-ны тогтоол гаргуулсан.
		1.6 энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг УИХ-ын 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах;	УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Үндэсний аудитын газраас "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Эрдэнэс Монгол" ХХК-д өгсөн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар холбогдох чиглэл өгч ажилласан.
		3/ Монгол Улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани, консорциумаар гүйцэтгүүлэх;	Монгол Улсаас экспортлох нүүрс, уул уурхайн бусад бүтээгдэхүүний тээвэрлэлтийн 50-иас доошгүй хувийг үндэсний тээврийн компани гүйцэтгэж байна.
4	Үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2015.04.17	2.1/үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/-нд даалгасугай: 1/"Монголын хөрөнгийн бирж" төхк-ийг өөрийн орны онцлог болон байгалийн баялагт суурилсан хөрөнгийн зах болгон хөгжүүлж, нэр хүндийг нь дээшлүүлэх, түүний үйл ажиллагаа, удирдлага, зохион	Тухайн үед уг заалтын дагуу "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, ҮЦТТТХТ-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, зохих зөвлөмж, дүгнэлтийг өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.

		<p>байгуулалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлж гадаад орны хөрөнгийн бирж, бусад байгууллагатай бизнесийн зарчмаар ижил тэгш харьцах боломжтой, үр ашигтай, улс орны эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах хөшүүрэг болохуйц байдлаар хувьчлахад бэлтгэх ажлын хэсгийг холбогдох байгууллагуудтай хамтран 2015 оны 2 дугаар улиралд багтаан байгуулж ажиллуулах;</p>	
		<p>2.2 үнэт цаасны зах зээлийн онцлогийг харгалзан “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон “үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК зэрэг төрийн өмчит өөрийгөө зохицуулах мэргэжлийн байгууллагуудыг мэргэшсэн удирдлагын багаар удирдуулах, эдгээр байгууллагуудын цаашдын хөгжлийн стратеги, бодлогыг нь Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомж, бодлого чиглэлтэй уялдуулах шаардлагын үүднээс туз-ийн, бүрэлдэхүүнд сангийн яам, санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкны шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтныг томилон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, үнэт цаас гаргагчдын төлөөллийг тус тус оролцуулж, шинээр байгуулж ажиллуулах,</p>	<p>Сангийн сайдын 2014 оны 131 тушаалаар Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо зэргээс тус тус мэргэшсэн удирдлагын багийг томилон ажиллуулж байна. Засгийн газрын 2015 оны 147 тогтоолоор ҮЦТТТХТөв ХХК-ийг өөрчлөн зохион байгуулан "Арилжааны төлбөр тооцоо ХХК, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК гэсэн 2 компани болгон хуваах шийдвэр гарсан. Тус тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Сангийн сайдын 2015 оны 284 болон 285 дугаар тушаалаар шинээр байгуулагдаж буй 2 компанийн ТУЗ-д Сангийн яам, Монгол банк, МХБ-ээс тус тус мэргэшсэн удирдлагуудыг томилон ажиллуулж байна.</p>
		<p>2.3 үнэт цаасны зах зээлд ашиглаж байгаа програм хангамжийн өнөөгийн байдалд дүгнэлт хийж, “майти” системийг цаашид боловсронгуй болгож, уг систем нь зах зээлийг хөгжүүлэхэд саадгүй ажиллаж байх нөхцөлийг бүрдүүлэх шуурхай арга хэмжээ авах;</p>	<p>Тухайн үед уг заалтын дагуу "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, ҮЦТТТХТ-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, зохих зөвлөмж, дүгнэлтийг өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.</p>

		<p>2.4 Монголбанк, санхүүгийн зохицуулах хороо, сангийн яамны ажлын уялдаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, санхүүгийн салбарын болон үнэт цаасны зах зээлийн хөгжлийн асуудалтай холбоотой аливаа харилцаанд санхүүгийн зохицуулах хорооны оролцоог хангаж, дүрэм, журам, гэрээ, хэлэлцээр, баримт бичигт түүний санал, дүгнэлтийг авч ажиллах,</p>	<p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдааныг 2015 онд 4 удаа зохион байгуулж, хуралдаанаар эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, холбогдох хууль эрх зүйн, төсөв, мөнгөний бодлогын асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.</p> <p>Хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг даатгалд хамруулах тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн, хуралдааны шийдвэрийн дагуу холбогдох зөвлөмж дүгнэлт, үүрэг даалгаврыг хариуцсан газруудада хүргүүлсэн болно.</p> <p>Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдааныг 2016.01.14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хурлаар инфляцийн төлөв байдлын тайлан, активийн удирдлагын тогтолцоо, зээлийн хоёрдогч захыг хөгжүүлэх талаар банкуудтай хамтран ажиллах тухай, үндсэн хуулийн цэцийн тогтоолтой холбоотой үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалтын талаар авах арга хэмжээний тухай, санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл, гадаад валютын дотоодын захын тойм, СТБЗ-ийн ажлын албаны мэдээлэл зэрэг багц асуудлыг хэлэлцэв.</p>
		<p>2.5 “ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн компанийн хувьцааны 10-аас доошгүй хувь, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьцааны тодорхой хэсгийг дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах, хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх, уул уурхайн салбарын төрийн өмчит компаниудад хөрөнгийн зах зээлд байнга оролцон санхүүжилт босгохтой холбогдсон эрх зүйн орчныг бүрдүүлэх, орд газрын үнэлгээ хийх</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2015 оны 36 дугаар тогтоолын 1.2 дахь хэсэгт заасан ажлын хүрээнд Монголын хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн нийт хувьцааны тодорхой хэсгийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжжлах замаар зах зээлийн багтаамж, хөрөнгө оруулагчдын хандлагыг тандах зэрэг давуу талтайг арилжааг эхний ээлжинд хийж байна.</p>

		<p>аргачлалыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулах, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, үнэлгээний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний аудитын компанийг бий болгох, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнэтэй тэнцэхүйц үнээр борлуулахад “эрдэс баялгийн бирж”-ийг байгуулах зэрэг ажлыг зохион байгуулах хамтарсан ажлын хэсгийг уул уурхайн яам, санхүүгийн зохицуулах хороо, төрийн өмчийн хороо болон холбогдох бусад төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах.</p>	
		<p>3/ энэ тогтоолын биелэлтийн талаар 2015 оны 10 дугаар сард багтаан эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Тухайн үед уг заалтын дагуу "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, ҮЦТТХТ-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, зохих зөвлөмж, дүгнэлтийг өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авсан.</p>
5	<p>Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай</p> <p>2015.04.17 №:12</p>	<p>2. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцыг 2015 оны сүүлийн хагаст багтаан Монгол Улсын Их Хурлын эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.</p> <p>2/ "МИАТ" ХК-ийн худалдан авсан “Боинг 767-300er” болон худалдан авах “Боинг 737-max” маркийн онгоцны төлбөрийг иргэний нисэхийн ерөнхий газрын навигацийн улсын төсөвт төвлөрүүлдэг орлогоос зээлийн гэрээний үндсэн дээр шийдвэрлэх;</p>	<p>Монголын агаарын тээврийн салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаарх УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар тайлбар, танилцуулгыг 2015.12.23-ны 01/5887 албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>"МИАТ" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг дэмжих хүрээнд Боинг 767 агаарын хөлгийн 2015 оны 1 ба 2 дугаар улирлын зээлийн төлбөрийг Хөгжлийн банкны өөрийн эх үүсвэрээс төлж гүйцэтгэсэн.</p> <p>2016 оны төлбөр болох 31,5 тэрбум төгрөгийг ИНЕГ-аас улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос шийдвэрлэх зорилгоор Зам, тээврийн сайдын 2016 оны багцад нэмж тусгуулсан.</p> <p>Үүнтэй холбоотойгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын навигацийн орлогыг 2015 онд 78,4 тэрбум төгрөгөөр баталж байсан бол 2016 онд 124,4 тэрбум төгрөг байхаар нэмэгдүүлэн тооцоолсон</p>

			<p>болно.</p> <p>Гэвч энэхүү нэмэлт санхүүжилтийн төсөв 2016 оны Улсын төсөв УИХ-аар батлагдахад хасагдсан.</p> <p>2015 онд “МИАТ” ТӨХК нь 5.3 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тул зээлийн төлбөрийг өөрийн эх үүсвэрээс төлөх боломжтой болсон.</p>
		<p>З/иргэний нисэхийн салбарын үндсэн мэргэжлийн буюу нисгэгч, инженер техникийнажилтны мэргэжлийн түвшнийг хадгалж, тогтвор суурьшилтай ажиллуулах, давтан сургах, нөөц бүрдүүлэх, залгамж халаа бэлтгэх замаар аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>"ИНЕГ-ын даргын 2010 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, чадавхийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр 2010-2018"-ийн хүрээнд жил бүр сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Иргэний нисэхийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, эрэлт хэрэгцээ, шаардлагыг судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/833 дугаар тушаалаар батлуулсан. Энэхүү хөтөлбөрт иргэний нисэхийн үндсэн мэргэжлийн болон бусад мэргэжлийн ажилтныг өндөр хөгжилтэй, үндсэн англи хэлтэй орнуудад бэлтгэх, бэлтгэгдсэн боловсон хүчнийг дадлагажуулах, мэргэшүүлэх, ур чадварыг хадгалах, олон улсын түвшинд өрсөлдөх чадварыг бий болгох, карьер хөгжлийг нэвтрүүлэх зэрэг хүний нөөцийн хөгжлийн зорилт, бодлого, стратегийг тодорхойлсон болно. 2016 онд ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах зорилтын хүрээнд ИНЕГ-ын Нисэхийн сургалтын төвд 76 сургалтад 1379 ажилтан, гадны байгууллагуудын 38 сургалтад 159 ажилтанг тус тус хамруулаад байна.</p> <p>Хүний нөөц бүрдүүлэх, залгамж халаа бэлтгэх зорилгоор шаардлагатай мэргэжлээр 2016 онд шинээр 18 оюутанг тус байгууллагын зардлаар</p>

			<p>суралцуулахаар гэрээ байгуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар байгууллагын зардлаар 91 оюутан бэлтгэгдэж байна.</p> <p>Хувийн агаарын тээврийн компаниуд, нисэх буудлууд болон тээвэр зуучийн байгууллагын ажилтнуудад 18 удаа сургалт зохион байгуулж, 134 хүнийг хамруулсан.</p>
Нийт 5 тогтоолын 21 заалтыг хяналтаас хасах саналтай ирүүлсэн болно.			